

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн
тушаалын хавсралт



ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, энэ хүрээнд хийсэн ажлын хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, үр дүнг тооцох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад оршино.

Хоёр. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын зохион байгуулалт

2.1. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын ачааллыг тэнцүүлэх зорилгоор аймаг, сум, нийслэл, дүүргийн хүн ам, барилга байгууламжийн төвлөрлөөр нь таван зэрэглэлд хуваана.

2.1.1. Нэгдүгээр зэрэглэлд: (нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг)

2.1.2. Хоёрдугаар зэрэглэлд: (Дархан-Уул, Орхон аймаг)

2.1.3. Гуравдугаар зэрэглэлд: (Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Ховд, Хөвсгөл аймаг)

2.1.4. Дөрөвдүгээр зэрэглэлд: (Говьсүмбэр, Дундговь, Төв, Булган, Сэлэнгэ, Хэнтий, нийслэлийн Багануур, Налайх дүүрэг, Сэлэнгэ аймгийн Мандал сум)

2.1.5. Тавдугаар зэрэглэлд: (нийслэлийн Багахангай дүүрэг, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Баянхонгор аймгийн Бууцагаан сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Айраг сум, Дорнод аймгийн Халхгол сум, Баян-Уул сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Тэс сум, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Сайхан сум, Увс аймгийн Баруунтуруун сум, Ховд аймгийн Булган сум, Төв аймгийн Батсүмбэр сум, Хөвсгөл аймгийн Тариалан, Хатгал сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Батноров сум)

2.2. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлыг дараах чиглэлд ангилж дүгнэнэ. Үүнд:

2.2.1. Нийслэл, дүүргийн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч;

2.2.2. Аймаг, сумын гал түймрийн улсын (ахлах) хяналтын байцаагч;

2.2.3. Гал түймрийн улсын хяналт /жижүүр/-ийн байцаагч;

2.2.4. Гэрээт гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч;

2.2.5. Барилгын зураг төслийн улсын хяналтын (ахлах) байцаагч;

Гурав. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн улиралд хийсэн байвал зохих ажил

3.1. Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч тус бүр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд улиралд дараах үзүүлэлтийг хангаж, үр дүнг хариуцна. Үүнд:

3.1.1. Нэгдүгээр зэрэглэл-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах

шаардлагатай объектын 60-аас доошгүй хувьд, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулна.

3.1.2.Хоёрдугаар зэрэглэл-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай объектын 80-аас доошгүй хувьд, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулна.

3.1.3.Гуравдугаар зэрэглэл-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай объектын 80-аас доошгүй хувьд, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулна.

3.1.4.Дөрөвдүгээр зэрэглэл-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай объектын 100 хувьд, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулна.

3.1.5.Тавдугаар зэрэглэл-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай объектын 100 хувьд, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулна.

3.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн хүрээнд зохион байгуулж эрх зүйн баримт бичиг (албан шаардлага, мэдэгдэл, танилцуулга, дүгнэлт, зөвлөмж, ажиллагаа зогсоох тогтоол, гал түймэр гарсан тухай акт) үйлдэж биелэлтийг хангуулна.

3.3.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд гүйцэтгэж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 70-аас доошгүй хувьд зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах арга хэмжээг авна.

3.4.Галын аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандарт зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 6.7 хэсэгт заасан ажиллагааг тухай бүр хийж, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг харьяа Прокурорын газарт хуулийн хугацаанд хүргүүлж хянуулна.

3.5.Нийслэл, дүүргийн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч дараах баримт бичгийг хөтөлнө.

3.5.1.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтын баримт бичиг;

- удирдамж
- мэдэгдэх хуудас
- хяналт шалгалтын тэмдэглэл
- хяналтын хуудас
- эрх зүйн баримт бичиг
- эрх зүйн баримт бичгийн хариу
- гүйцэтгэлийн хяналт шалгалтын тэмдэглэл,
- хяналт шалгалтын танилцуулга, илтгэх хуудасны хамт

3.5.2.Зөрчил шалган шийдвэрлэсэн материал;

- зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны бүртгэл
- зөрчлийн хэрэг
- хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материал
- харьяаллын дагуу шилжүүлсэн материал

➤ шийтгэлийн хуудасны бүртгэлийг Засгийн газрын 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт /шийтгэлийн хуудасны маягт хэрэглэх журам/-ын дагуу хөтлөх;

- эрх бүхий албан тушаалтны албан даалгавар
- шүүхэд шилжүүлсэн материал

3.5.3. Гал түймэр гарсан тухай акт;

- хүсэлт
- гал түймэр унтраасан нотломж
- илтгэх хуудас
- хохирлын үнэлгээ
- гэрэл зургийн үзүүлэлт
- бусад холбогдох материал

3.5.4. Галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон материал;

- хүсэлт
- бусад холбогдох материал
- хяналт шалгалтын тэмдэглэл
- хяналтын хуудас
- албан шаардлага, зөвлөмж, мэдэгдэл
- албан шаардлага, мэдэгдэл, зөвлөмжийн хариу
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
- бүртгэл

3.6. Аймаг, сумын гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч дараах баримт бичгийг хөтөлнө.

3.6.1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтын баримт бичиг; (журмын 3.5.1.-д заасан баримт бичиг)

3.6.2. Барилга байгууламжийн зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлтийн материал;

- хүсэлт
- бусад холбогдох материал,
- галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлт
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
- бүртгэл

3.6.3. Зөрчил шалган шийдвэрлэсэн материал; (журмын 3.5.2-д заасан баримт бичиг)

3.6.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажилласан баримт бичиг;

- мэдэгдэх хуудас
- ашиг сонирхлын зөрчилгүй болон зөрчил үүссэн тухай мэдэгдлийн хуудас
- өгсөн үүрэг даалгаврын тэмдэглэл
- үүрэг даалгаврын биелэлт
- бүртгэл

3.6.5. Гал түймэр гарсан тухай акт, шинжээчийн дүгнэлт; (журмын 3.5.3.-д заасан бичиг баримт, шинжээчээр томилсон тогтоол)

3.6.6.Галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон материал; (журмын 3.5.4.-д заасан баримт бичиг)

3.7.Гэрээт гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч дараах баримт бичгийг хөтөлнө.

3.7.1.Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан (хагас жил,сүүлийн хагас жил)

3.7.2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтын баримт бичиг; (журмын 3.5.1.-д заасан баримт бичиг)

3.7.3.Зөрчил шалган шийдвэрлэсэн материал; (Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 6.7 заалтыг хэрэгжүүлсэн байдал)

3.7.4.Галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон бүртгэл;(журмын 3.5.4.-д заасан баримт бичиг)

3.7.5.Гэрээлэгч байгууллагын барилга, байгууламжийн гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө;

3.7.6.Гэрээлэгч байгууллагын ажилчдад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан материал;

- сургалтын төлөвлөгөө
- сургалтын материал
- бүртгэл
- шалгалт авсан материал
- илтгэх хуудас

3.7.7.Гэрээлэгч байгууллагын объектын судалгаа;

➤ гал түймрийн илрүүлэх, мэдээлэх, унтраах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон объект

➤ гал түймэр унтраах даралтад усны цэг гидрант, худгийн судалгаа

3.8.Гал түймрийн улсын хяналтын (жижүүр)-ийн байцаагч дараах баримт бичгийг хөтөлнө.

3.8.1.Гал түймрийн хэрэг дээр ажилласан материал, бүртгэл; (Зөрчлийн хэрэг харьяаллын дагуу шилжүүлсэн материал)

3.8.2.Дотоод ажил;

- хоногийн нөхцөл байдлын мэдээ
- танилцуулга
- гал түймрийн бүртгэл
- гомдол мэдээллийн бүртгэл
- нотломжийн бүртгэл

3.9.Барилгын зураг төслийн хяналтын улсын (ахлах) байцаагч нь:

3.9.1.Барилга байгууламжийн зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлтийн материал; (журмын 3.6.2.-д заасан баримт бичиг)

3.9.2.Зөрчил шалган шийдвэрлэсэн материал; (журмын 3.5.2.-д заасан баримт бичиг)

3.9.3.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажилласан баримт бичиг; (журмын 3.6.4.-д заасан баримт бичиг)

3.9.4.Төлөвлөгөөт бус хяналт шалгалт;(журмын 3.5.1.-д заасан баримт бичиг)

Дөрөв. Дүгнэх хугацаа, аргачлал

4.1.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлыг дараах маягтаар дүгнэнэ.

- (Маягт-1)-ээр нийслэл, дүүргийн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч,
- (Маягт-2)-оор аймаг, сумын гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч,
- (Маягт-3)-аар гал түймрийн улсын хяналтын (жижүүр)-ийн байцаагч,
- (Маягт-4.1)-ээр гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч,
- (Маягт-4.2)-оор худалдааны төвийн гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч,
- (Маягт-4.3)-аар гал түймэртэй тэмцэх хэсэг,
- (Маягт-5)-аар барилгын зураг төслийн хяналтын улсын байцаагчийн ажлыг тус тус дүгнэнэ.

4.2 Дүүргийн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн ажлыг дүгнэх аргачлал

4.2.1.“Төрийн хяналт шалгалт” гэсэн хэсгийг дараах байдлаар дүгнэнэ.

- Төлөвлөгөөт хяналт шалгалтыг дүгнэхдээ

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай нийт объектыг дүүргийн байцаагчид дараах байдлаар хувилж тооцож хуваана ахлах байцаагч 20 хүртэлх хувьд, байцаагч 40 хүртэлх хувьд хяналт шалгалт хийж 100 хүртэлх хувиар тооцож дүгнэнэ. Орон тоо дутуу, ээлжийн амралттай тохиолдолд 3.1.1-д заасан объектыг ахлах байцаагчид 40 хувь, байцаагчид 60 хувийн харьцуулан тооцох зарчмаар журмын 3.1.1, 3.1.4, 3.1.5-д заасан хамруулбал зохих хувьд харьцуулан 100 хүртэлх хувиар тооцож дүгнэнэ.

(Жишээ: Баянзүрх дүүргийн ГТУХБ эхний улиралд 2 төлөвлөгөөт хяналт шалгалт болох Банк санхүүгийн байгууллагын барилга байгууламж, худалдааны төвийн барилга байгууламжид хяналт шалгалт хийсэн. Дээрх 2 төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт хамрагдвал зохих 320 объекттой. Журмын 3.1.1-д зааснаар 60 хувийг хувилж тооцвол $320 \cdot 60 / 100 = 192$ объектыг шалгалтад хамруулсан байвал зохино. Үүнээс ахлах байцаагч $192 \cdot 20 / 100 = 38$ объектод, 2 байцаагчтай тохиолдолд байцаагч тус бүр $192 \cdot 40 / 100 = 77$ объектод хяналт шалгалт хийсэн тохиолдолд 100 хувь гэж үнэлгээг өгнө.)

•Төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлтийг дүгнэхдээ төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр хариу ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ. Албан шаардлага, мэдэгдэлд тусгагдсан биелэлтийн хугацаа болоогүй тохиолдолд дараагийн улиралд оруулж тооцно.

•Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дүгнэхдээ эрх бүхий байгууллага (Засаг дарга, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга г.м) удирдамж, иргэн хуулийн этгээдийн гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр хариу ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

- Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг дүгнэхдээ иргэн хуулийн

этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр хариу ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

4.2.2. "Гал түймрийн хэрэг шийдвэрлэлт" гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улиралд гарсан гал түймрийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдлыг 100 хүртэл хувиар дүгнэнэ.

4.2.3. "Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ хүн хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийг заасан хугацаанд ирүүлээгүй болон биелүүлээгүй зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдлыг харгалзан 100 хүртэл хувиар дүгнэнэ. (Энэ хэсэг нь маягт 1-ийн төрийн хяналт шалгалтын хэсэгт хамаарна)

4.2.4. "Нийт ажлын дундаж хувь"-ийг олохдоо төрийн хяналт шалгалт, гал түймрийн хэрэг шийдвэрлэлт, Зөрчил шалган шийдвэрлэсэн байдлын нийлбэрийг 3-т хувааж дундаж хувийг олно. Нийт ажлын дундаж хувийг оноонд шилжүүлэхдээ дундаж хувийг авбал зохих 75 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авсан оноо гарна. Нийт ажлын дундаж хувийг дараах томъёогоор тооцно.

$$H_{\text{ажил}}^{\text{д}} = \frac{Z_{\text{хувь}}^{\text{дундаж}} \cdot 75}{100}$$

$H_{\text{ажил}}^{\text{д}}$ - Нийт ажлын дундаж хувь

$Z_{\text{хувь}}^{\text{дундаж}}$ - төрийн хяналт шалгалт, гал түймрийн хэрэг шийдвэрлэлт, зөрчил шалган шийдвэрлэсэн байдлын дундаж хувь

$$Z_{\text{хувь}}^{\text{дундаж}} = \frac{H_{\text{нийлбэр хувь}}}{3}$$

4.2.5. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5- 15 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.2.6. "Бусад ажил" гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улиралд нийслэл, дүүргээс зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээнд хамрагдсан байдлыг харгалзан 10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.2.7. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн улирлын ажлын нийт дүнг гаргахдаа дараах томъёогоор тооцно.

$$X_{\text{улирал дүн}} = H_{\text{ажил}}^{\text{д}} + H_{\text{м/тайлан}} + H_{\text{б/ажил}}$$

4.3. Аймаг, сумын гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн ажлыг дүгнэх аргачлал

4.3.1. "Төрийн хяналт шалгалт" гэсэн хэсгийг дараах байдлаар дүгнэнэ.

- Төлөвлөгөөт хяналт шалгалтыг дүгнэхдээ;

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай нийт объектыг аймгийн байцаагчид хувааж журмын 3.1.1-3.1.5-д заасан хамруулбал зохих хувьд харьцуулан 100 хүртэлх хувиар тооцож дүгнэнэ.

(Жишээ: Орхон аймаг эхний улиралд 2 төлөвлөгөөт хяналт шалгалт болох боловсролын байгууллагын барилга байгууламж, газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг борлуулдаг иргэн хуулийн этгээдийн барилга байгууламжид хяналт шалгалт явагдсан нийт хамрагдвал зохих сургууль, цэцэрлэг, их дээд сургуулийн объект 65, газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг, иргэн хуулийн этгээдийн барилга байгууламж 45 гэж тооцвол $65+45=110$ объект

хамрагдах шаардлагатай Орхон аймгийн 2 байцаагчид тэнцүү хуваавал тус бүрд 55 объект ноогдож байна. Зэрэглэлээр Орхон аймаг 2-р зэрэглэлд багтаж байгаа ба $55 \times 80 / 100 = 44$ буюу нэг байцаагч 44 объектод хяналт шалгалт хийсэн тохиолдолд 100 хувь гэж үнэлгээг тооцно.)

- Төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлтийг дүгнэхдээ хяналт шалгалтын хүрээнд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр хариу ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ. Албан шаардлага, мэдэгдэлд тусгагдсан биелэлтийн хугацаа болоогүй тохиолдолд дараагийн улиралд оруулж тооцно.

- Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дүгнэхдээ эрх бүхий албан тушаалтын баталсан (аймгийн засаг дарга, онцгой байдлын газрын дарга г.м) удирдамж, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

- Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг дүгнэхдээ иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

4.3.2.“Гал түймрийн хэрэг шийдвэрлэлт” гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улиралд гарсан гал түймрийн шийдвэрлэлтийг харгалзаж 100 хүртэл хувиар дүгнэнэ.

4.3.3.“Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал” гэсэн хэсгийг дүгнэхдээ хүн хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийг заасан хугацаанд ирүүлээгүй болон биелүүлээгүй зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдлыг харгалзан 100 хүртэл хувиар дүгнэнэ. (Энэ хэсэг нь маягт 2-ын төрийн хяналт шалгалтын хэсэгт хамаарна)

4.3.4.“Барилгын зураг, улсын комисс” гэсэн хэсгийг дүгнэхдээ иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлалыг журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн байдалд 50 хүртэлх хувь, барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажиллаж үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулсан эсэхэд 50 хүртэлх хувиар дүгнэнэ.

4.3.5.“Нийт ажлын дундаж хувь”-ийг олохдоо энэ журмын 4.2.4.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.3.6.“Мэдээ, тайлан ирүүлсэн байдал” гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5- 15 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.3.7.“Хандлага, ёс зүй, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал” гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улиралд сахилга ёс зүйн зөрчил гаргаагүй, мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажилд 10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.3.8.Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн улирлын ажлын нийт дүнг энэ журмын 4.2.7.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.4.Гал түймрийн улсын хяналт /жижүүр/-ийн байцаагчийн ажлыг дүгнэх аргачлал

4.4.1.“Үүрэг гүйцэтгэл” гэсэн хэсгийг дүгнэхдээ ээлжид үүрэг гүйцэтгэсэн ажилд хувь тавьж авбал зохих 15 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.4.2.“Харьяаллын дагуу шилжүүлсэн” гэсэн хэсгийг дүгнэхдээ ээлжид үүрэг гүйцэтгэх хугацаанд гарсан гал түймрийн хэргийг шийдвэрлэсэн байдалд хувь

тавьж авбал 25 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.4.3. "Дотоод ажил" гэсэн хэсгийг дүгнэхдээ удирдах албан тушаалтанд хоногийн мэдээ танилцуулж, шийдвэрлүүлсэн ажилд хувь тавьж авбал зохих 15 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.4.4. "Баримт бичиг хөтлөлт" гэсэн хэсгийг дүгнэхдээ гал түймрийн улсын хяналтын (жижүүр)-ийн байцаагчийн хөтлөгдөх баримт бичигт хувь тавьж авбал 20 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.4.5. "Нийт ажлын дундаж хувь"-ийг олохдоо энэ журмын 4.2.4.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.4.6. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5- 15 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.4.7. "Хандлага, ёс зүй, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улиралд сахилга ёс зүйн зөрчил гаргаагүй, мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажилд 10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.4.8. Гал түймрийн улсын хяналтын (жижүүр)-ийн байцаагчийн улирлын ажлын нийт дүнг энэ журмын 4.2.7.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.5. Худалдааны төвийн гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн ажлыг дүгнэх аргачлал.

4.5.1. "Төрийн хяналт шалгалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ хяналт шалгалтын төлөвлөгөөнд заагдсан объектын тоог тооцож, хувиар дүгнэнэ.

4.5.2. "Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ хүн хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийг заасан хугацаанд ирүүлээгүй болон биелүүлээгүй зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдлыг харгалзан 100 хүртэл хувиар дүгнэнэ.

4.5.3. "Эрх зүйн баримт бичиг" гэсэн хэсгийг дүгнэхдээ хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

4.5.4. "Сургалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ танхимын сургалтыг улиралд 3 удаа, дадлага сургалтыг улиралд 1 удаа тус тус зохион байгуулсан тохиолдолд 100 хувиар дүгнэнэ.

4.5.5. "Нийт ажлын дундаж хувь"-ийг олохдоо энэ журмын 4.2.4.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.5.6. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5- 10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.5.7. "Үүрэг даалгаврын биелэлт" гэсэн хэсгийг дүгнэхдээ удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтэд хувь тавьж авбал зохих 15 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.5.8. Гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн улирлын ажлын нийт дүнг энэ журмын 4.2.7.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.6. Гал түймэртэй тэмцэх хэсгийн дарга, гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн ажил дүгнэх аргачлал

4.6.1. "Төрийн хяналт шалгалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх шалгалтад хамрагдвал зохих нийт объектын тоог тооцож, хувиар дүгнэнэ.

4.6.2. "Эрх зүйн баримт бичиг" гэсэн хэсгийг дүгнэхдээ хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож дүгнэнэ.

4.6.3. "Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ гүйцэтгэлийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцсоныг харьцуулж хувийг тооцно. Байцаагчийн хариуцан ажилладаг нутаг дэвсгэр, объектод гал түймрийн зөрчил гарсан бол Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу ажиллагаа явуулсан бол хувь тавьж авбал зохих оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.6.4. "Сургалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ танхимын сургалтыг улиралд 6 удаа, дадлага сургалтыг улиралд 1 удаа тус тус зохион байгуулсан тохиолдолд 100 хувиар дүгнэнэ.

4.6.5. "Дотоод ажил" гэсэн хэсгийг дүгнэхдээ хүснэгтэд заагдсан ажлыг зохион байгуулсан бол хувь тавьж авбал зохих оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.6.6. "Судалгаа" гэсэн хэсгийг дүгнэхдээ объектын судалгаанд тодотгол хийсэн байдалд хувь тавьж авбал зохих оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.6.7. "Нийт ажлын дундаж хувь"-ийг олохдоо энэ журмын 4.2.4-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.6.8. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5- 10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.6.9. "Үүрэг даалгаврын биелэлт" гэсэн хэсгийг дүгнэхдээ удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтэд хувь тавьж авбал зохих 10 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.6.10. Гал түймэртэй тэмцэх хэсгийн дарга, гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн улирлын ажлын нийт дүнг энэ журмын 4.2.7-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.7. Гэрээт гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн ажил дүгнэх аргачлал

4.7.1. "Төрийн хяналт шалгалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ хяналт шалгалтын төлөвлөгөөнд заагдсан объектын тоог тооцож 100 хүртэлх хувиар дүгнэнэ.

4.7.2. "Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ хүн хуулийн этгээдэд зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийг заасан хугацаанд ирүүлээгүй болон биелүүлээгүй зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байдлыг харгалзан 100 хүртэл хувиар дүгнэнэ.

4.7.3. "Эрх зүйн баримт бичиг" гэсэн хэсгийг дүгнэхдээ хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий этгээдэд хүргүүлсэн албан шаардлага, мэдэгдлийн заалт тус бүрээр ирүүлсэн биелэлтийг хувилж тооцож 100 хүртэлх хувиар дүгнэнэ.

4.7.4. "Сургалт" гэсэн хэсгийг дүгнэхдээ танхимын сургалтыг улиралд 6 удаа, дадлага сургалтыг улиралд 1 удаа тус тус зохион байгуулсан тохиолдолд 100 хүртэлх хувиар дүгнэнэ.

4.7.5. "Комисс" гэсэн хэсгийг дүгнэхдээ хүснэгтэд заагдсан ажлыг зохион байгуулсан бол хувь тавьж авбал зохих оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна. (энэ хэсэг нь комиссоор ажилласан тохиолдолд ажлын үзүүлэлтэд хамаарна)

4.7.6. "Нийт ажлын дундаж хувь"-ийг олохдоо энэ журмын 4.2.4-т заасан аргачлалын дагуу тооцно.

(төрийн хяналт шалгалт, эрх зүйн баримт бичиг, зөрчил шалган шийдвэрлэсэн, сургалт, комисс нийт гарсан хувийн нийлбэрийг 5-д хувааж дундаж хувийг олно. Хяналт шалгалтын ажлын дундаж хувийг оноонд шилжүүлэхдээ дундаж хувийг авбал зохих 80 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авсан оноо гарна).

4.7.7. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5-10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.7.8. "Үүрэг даалгаврын биелэлт" гэсэн хэсгийг дүгнэхдээ удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтэд хувь тавьж авбал зохих 10 оноогоор үржүүлж 100 хувьд хувааснаар авах оноо гарна.

4.7.9. Гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн улирлын ажлын нийт дүнг энэ журмын 4.2.7.-т заасан аргачлалын дагуу тооцно.

4.8. Барилгын зураг төсөл хяналтын улсын байцаагчийн ажил дүгнэх аргачлал

4.8.1. "Барилгын зураг төсөлд магадлал хийсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлалыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдалд 20 хүртэл оноогоор дүгнэнэ.

4.8.2. "Улсын комисст ажиллах" гэсэн хэсгийг барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажиллаж, үүрэг биелэлтийг хангуулсныг 50 оноогоор дүгнэнэ.

4.8.3. "Мэдээ, тайлан ирүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ холбогдох мэдээ, тайланг ирүүлсэн хугацаа, утга найруулга, чанар, агуулга, стандарт зэрэгт 5-10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

4.8.4. "Хандлага, ёс зүй, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал" гэсэн хэсгийг дүгнэхдээ тухайн улирал, хагас, бүтэн жилд сахилга ёс зүйн зөрчил гаргаагүй, мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажилд 15 хүртэл оноогоор дүгнэнэ.

4.8.5. Гал түймрийн улсын хяналтын (жижүүр)-ийн байцаагчийн улирал, хагас, бүтэн жилд хийсэн ажлыг нэгтгэн дүгнэхдээ барилгын зураг төсөлд магадлал хийсэн байдал, улсын комисст ажиллах, мэдээ тайлан ирүүлсэн байдал, хандлага, ёс зүй мэдлэг чадвараа дээшлүүлэх байдлын онооны нийлбэр нь нийт оноо болно.

4.9. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн улирал, хагас, бүтэн жилд хийсэн ажлын нийт оноонд дүйцүүлэн дараах үнэлгээг олгоно.

90-100 оноо авсан бол "А" буюу "Маш сайн";
80-90 хүртэл оноо авсан бол "В" буюу "Сайн";
70-80 хүртэл оноо авсан бол "С" буюу "Хангалттай";
60-70 хүртэл оноо авсан бол "D" буюу "Дутагдалтай";
0-60 хүртэл оноо авсан бол "F" буюу "Хангалтгүй";

Тав. Дүгнэх хугацаа, баталгаажуулалт

5.1. Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн ажлыг улирал бүр сүүлийн сарын 20-ны өдрийн дотор Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, (Гэрээт гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн) дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын

хяналтын хэлтэст inspector.obeg@gmail.com цахим хаягаар баталгаажуулан ирүүлнэ.

5.2.Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар Гал түймрийн улсын хяналтын байцаагч нарын ажлыг жилийн эцэст нэгтгэн дүгнэж байр эзлүүлнэ.

5.3.Жилийн эцсийн дүнгээр “Маш сайн” дүгнэгдсэн алба хаагчдыг урамшуулах, “Хангалтгүй” дүгнэгдсэн алба хаагчдад хариуцлага тооцох саналыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд Гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчид уламжлан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлүүлнэ.

---oOo---

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журмын хавсралт 2

..... АЙМАГ, СУМЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
(АХЛАХ) БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Маягт-2

[illegible]

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
(ЖИЖҮҮР)-ИЙН БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭСЭН ҮЗҮҮЛЭЛТ

					Нийслэл нэр
					Байцаагчийн цол, овог нэр
					Ээлжид үүрэг гүйцэтгэсэн тоо
					Үүрэг гүйцэтгэх үед гарсан гал түймрийн
					Материалжуулсан тоо
					Мэдээллээр ажилласан тоо
					Шинжээчтэй ажилласан тоо
					15 оноо
					Хувь
					Сард хүлээн авсан Гал түймрийн тоо
					Дүүргийн ОБГ
					Цагдаагийн байгууллагад
					Гэрээт байгууллагад
					25 оноо
					Хувь
					Удирдах албан тушаалтанд хоногийн мэдээ танилцуулсан
					Шилжүүлэх саналын тоо
					15 оноо
					Хувь
					Гал түймрийн хэрэг бүртгэл
					Гомдол мэдээллийн бүртгэл
					Сарын нөхцөл байдлын танилцуулга
					Нотломжийн бүртгэл /ирц/
					20 оноо
					Хувь
					Ажлын дундаж хувь
					Авбал зохих нийт оноо /75/
					Авсан оноо
				15 оноо	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал
				хувь	
				10 оноо	Хандлага, ёс зүй, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал
				хувь	
					Нийт оноо
					Үнэлгээ

Гал түймрийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр

Маягт-3

ГЭРЭЭТ ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЖИЛ ДҮГНЭСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Гал түймрийн улсын хяналтын чиглэл					
Гэрээлэгч байгууллагын нэр	Эрх бүхий албан тушаалтны цол, овог нэр	Хяналт шалгалт	Хяналт шалгалт хийсэн байдал		
			Хувь		
		Эрх зүйн баримт бичиг	Албан шаардлага		
			Мэдэгдэл		
			Зөвлөмж		
			Хувь		
		Зөрчил шалган явуулсан шийдвэрлэсэн	Ажиллагаа явуулсан байдал		
			Хувь		
		Сургалт	Дадлага сургалт		
			Танхимын сургалт		
			Хувь		
		Комисс	Шинээр барилга баригдаж ашиглалтад улсын комисс хүлээн авах комисс		
			Барилга байгууламжид их засвар хийгдэж хүлээн авах бол техникийн комисс		
			Барилга байгууламж барих газар сонголтын комисс		
			Хариуцсан хэсэглэлийн хэмжээнд гэмтлийн акт тогтоох комисс		
			Хувь		
		Хяналт шалгалтын ажлын дундаж хувь			
		Авбал зохих нийт оноо /80/			
		Авсан оноо			
	10 оноо	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал			
	хувь				
	10 оноо	Үүрэг даалгаврын биелэлт			
	хувь				

ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ГЭРЭЭТ ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
АХЛАХ БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Маят-4.2

Гэрээлэгч байгууллагын нэр	Байцаагчийн цол, овог нэр	Гал түймрийн улсын хяналтын чиглэл												
		Төрийн хяналт шалгалт		Зөрчил шалган шийдвэрлэсэн байдал		Эрх зүйн баримт бичиг		Сургалт			Нийт ажлын дундаж хувь			
		хяналт шалгалт хийсэн байдал	Хувь	Ажиллагаа явуулсан байдал	Хувь	Албан шаардлага, Мэдэгдэл	Хувь	Танхимын сургалт	Дадлага сургалт	Хувь	Авбал зохих нийт оноо /75/	Авсан оноо	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал	Үүрэг даалгаврын биелэлт
													10 оноо	
													15 оноо	
													Нийт оноо	
													Үнэлгээ дүн	

**ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ХЭСГИЙН ДАРГА, ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
АХЛАХ БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

Гэрээлэгч байгууллагын нэр									
Эрх бүхий албан тушаалтны цол, овог нэр	Гал түймрийн улсын хяналтын чиглэл								
	Төрийн хяналт шалгалт		Эрх зүйн баримт бичиг			Зөрчил шалган шийдвэр лэсэн		Сургалт	
	Хяналт шалгалт хийсэн байдал		Хувь			Ажиллагаа байдал		Хувь	
			Албан шаардлага			Мэдэгдэл			
			Зөвлөмж			Хувь			
			Ажиллагаа байдал			Хувь			
			Дадлага сургалт сургууль			Танхимын сургалт			
			Хувь			Галтай ажил гүйцэтгэх үеийн зааварчилгааны бүртгэл			
			Хэсгийн алба хаагчдыг ажлыг дүгнэсэн байдал			Хувь			
			Объектын судалгаа			Гал түймэр унтраах тоног төхөөрөмж			
			Алба хаагчдын дэлгэрэнгүй судалгаа			Хувь			
			Хяналт шалгалтын ажлын дундаж хувь			Авбал зохих нийт оноо /80/			
			Авсан оноо			10 оноо	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал		
			хувь			хувь			
			10 оноо			Үүрэг даалгаврын биелэлт			
			хувь						
			Нийт оноо						
			Үнэлгээ дүн						

Маягт-4.3

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН
ХЯНАЛТЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН АЖИЛ ДҮГНЭСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Маягт-5

Зураг хяналтын байцаагч	Байцаагчийн цол, овог нэр	Гал түймрийн улсын хяналтын чиглэл							Нийт оноо	Үнэлгээ дүн
		Барилгын зураг төсөлд магадлал хийсэн байдал		Авсан оноо	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал		Хандлага, ёс зүй, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал			
		Зураг төслийн магадлал	Комиссын биелэлт		15 оноо	хувь	15оноо	хувь		
		20 оноо	50 оноо							
Нийслэлийн ОБГ										